Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Яамны дотоод асуудал, шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн, Мягмар Уранзул

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Яамны үйл ажиллагааны өдөр тутмын тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, төрийн захиргааны байгууллага, харьяа байгууллагын болон салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ. | | | | | | | |
| 1 | Яамны хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангахад албан хаагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. | Хэрэгжилтийн тоо | 2023 оны гүйцэтгэл | Байгууллагын дотоод журмын хэрэгжилт сайжирсан байна. | Боловсролын яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. 1. "Боловсрол, шинжлэх ухааны яамын албан хаагчдын эцэг эхийн зөвлөл"-ийг шинэчлэн батлах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/80 тушаал батлуулж, зөвлөлийн үйл ажиллагааг эхэлүүлсэн. 2. Албан хаагчдыг албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай компьютер, техник, хэрэгслээр хангах, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өрөө, тасалгааны засвар, үйлчилгээ, тохижилтод анхаарч холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав. Яамны 5 дугаар давхрын урд жигүүрийн засварын ажил, 1 дүгээр давхрын хурлын 115 тоот өрөөний засвар, 4 болон 5 дугаар давхрын 3 өрөөний засварын ажлыг гүйцэтгүүлэвв. 3.Яамны албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгийг АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран 2024 оны 06 дугаар сарын 07-гллм 07 дугаар сарын 6-ны өдрийг дуустал үе шаттайгаар зохион байгуулав. Энэ удаагийн үзлэг шинжилгээг цХавдрын урьдчилан сэргийлэх багц"-аар 28 төрлийн шинжилгээ, 7 төрлийн багажийн шинжилгээнд хамрууллаа. Тус үзлэгт албан хаагчдын 90 хувь хамрагдсан байна. 4. Журмын хэрэгжилтийн хүрээнд "Мэдээллийн цаг"-ийг товлогдсон хугацаанд зохион байгуулж цаг үеийн шинжтэй мэдээллийг тухай бүр хийж ажиллаа. 5.Цаг бүртгэлийн программд албан хаагчдын чөлөөтэй, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өвчтэй сургалттай байгаа мэдээллийг тухай бүр оруулсан. Төрийн нарийн бичгийн даргын баталсан яамны албан хаагчдын Ээлжийн амралтын 2024 оны хуваарийн дагуу мэдээллийг оруулав. 6.Төрийн нарийн бичгийн даргын Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай 43 тушаалын Ажил хүлээлцэх ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллан зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаа. 7.Хурлын танхим, заал, өрөөний захиалгын баталгаажилтыг хийн, хяналт тавьж ажиллаа. 8.Яамны албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллав. Төрийн нарийн бичгийн даргын "Журам шинэчлэн батлах тухай" 2024 оны А/93 дугаар тушаалаар 2022 оны А/41, 2023 оны А130 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгов.<br>Хавсралт: 4 файл | | |
| 2 | Байгууллагын соёлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг | Байгууллагын соёлын батлагдсан төлөвлөгөө | Байгууллагын соёлын батлагдсан төлөвлөгөө | Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжилт хангагдсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хаагчдаас 2024 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд Сэтгэл | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах ажиллах | | | | ханамжийн судалгааг авлаа. 5 бүлгийн 22 асуумж боловсруулан цахимаар авахад 106 албан хаагчаас 70 албан хаагч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчид ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, нийгмийн баталгаатай холбоотой мэдээллийг ил тод болгох, хэрэгжүүлэх, удирдлагын манлайлал, ёс зүйд анхаарах, албан хаагчдын сургалт, судалгаатай хөтөлбөр батлах, хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв баталж өгөх гэх мэт асуудлуудыг хөндсөн. Судалгааны дүгнэлтийн хүрээнд Байгууллагын соёлын үйл ажиллагаанд албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах зорилгоор Мэдээллийн цагийг тогтсон хугацаанд зохион байгуулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах, спортын арга хэмжээ зохион байгуулах, шаардлагатай сургалтад албан хаагчдаа хамруулах зэрэг ажлыг холбогдох газар хэлтсийн албан | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаагчидтай хамтран хийв. | | |
| 3 | Салбарын шагнал урамшууллын бодлого, зохицуулалтыг зохион байгуулах, сан бүрдэлтэд хяналт тавих | Нийт шагнагдсан албан хаагчдын тоо | 2023 оны шагнагдсан албан хаагчдын тоо | Шагнагдсан албан хаагчдын мэдээллийг шагналын сангийн мэдээлэлд оруулсан байна. | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн "Журам батлах тухай" А/496 дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинннжлэх ухааны салбарын албан хаагчид олгох журам, Боловсролын сайдын 2024 оны А/82 дугаар тушаалаар батлагдсан "Журам шинэчлэн батлах тухай" Боловсролын салбарын албан хаагчдад шагнал олгох журмын дагуу шагналыг шийдвэрлүүлэн, хүргүүлэх ажлыг зохион байгууллаа. 2024 онд 3450 Боловсролын тэргүүний ажилтан, 3855 Боловсролын жуух бичиг, 55 Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч, 5 Шинжлэх ухааны тэргүүний ажилтан тэмдгээр тус тус шагнасан байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Шагнах тухай" А/196 дугаар тушаал, Боловсролын сайдын Шагнах тухай 2024 оны А/23, А/128, А/221 тушаалыг тус тус баталгажууллаа. Чиг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үүргийн дагуу шагнагдсан албан хаагчдын мэдээллийг цахим мэдээллийн санд оруулахаар Боловсролын ерөнхий газарт тушаалыг хүргүүлэх, мэдээллийг шалгах ажлыг гүйцэтгэв. | | |
| 4 | Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа авах, шинжилгээ хийх, холбогдох арга хэмжээ авах | Судалгааны үр дүн | - | Асуулгын судалгааны үр дүнгээр холбогдох арга хэмжээний санал боловсруулан арга хэмжээ авсан байна. | Энэхүү судалгааны гол зорилго нь албан хаагчдаас ажлын байрны сэтгэл ханамж болон байгууллагын соёлын төлөвшлийг тодорхойлуулах, судалгаанд үндэслэн Байгууллагын соёлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх юм. Боловсрол, шинжлэх ухааны яаманд ажиллаж байгаа 106 албан хаагчаас ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 04 дүгээр сарын 15-17-ны өдрүүдэд авахад судалгаанд 70 албан хаагч буюу 89,3 хувь хамрагдсан байна. Судалгаанаас харахад албан хаагчид ажлаа хэвийн гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлд нэгжүүдийн ажлын уялдаа холбоо дутмаг гэж 31,9%, ажлын ачаалал их гэж 23,6 %, удирдлагын арга барил дутмаг гэж 16,7%, ажлын байрны | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дарамт, шахалттай гэж 8,3% тус тус дүгнэсэн байна. Гэхдээ Та эрхэлсэн ажилдаа сэтгэл хангалуун байна уу гэсэн асуулгад судалгаанд хамрагдсан албан хаагчдын 50% сэтгэл хангалуун, 41,4% сайн гэсэн хариулсан байна.  Байгууллагад нийгмийн асуудлыг анхаардаггүй, хүртээмж муу, санхүүгийн дэмжлэг үзүүлдэггүй, тэгш бус харьцдаг.  Ажиллагсдын нийгмийн баталгааны хөтөлбөр байдаггүй. Ялгавартай ханддаг гэх мэт асуудлуудыг хөндсөн. Мөн албан хаагч нараа дэмжсэн урамшуулсан бодлогыг нээлтэй тэгш байдалд баримтлан ажиллах нь чухал. Хүний нөөцийн ажилтан албан хаагч нарт ижил түвшинд Төрийн албаны тухай хуулиар олгогдсон эрхээ эдлэх боломжийг олгох тал дээр анхаарч ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа гэдгийг онцлон тэмдэглэе. Ялгавартай эрх, үүрэгтэй байгаагаас болж албан хаагч нарын харилцаа хандлагад сөрөг нөлөө үзүүлж байгууллагын соёл төлөвшихгүй байгаа тухай, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын соёлыг сайжруулах, албан хаагчдыг чадавхжуулахад нэгжийн дарга нарыг чадавхжуулахад анхаарах шаардлагатай байгаа талаар ч судалгаанд оролцогсод санал өгсөн. Үүнтэй уялдуулан 2025 онд албан хаагчдын орон сууц, сургалт, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд судалгаа хийх, холбогдох шийдвэрүүдийг үе шаттай гаргах талаар санал боловсруулахыг удирдлагаас чиглэл өгөөд байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 5 | “Мэдээллийн цаг”- зохион байгуулах төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах | "Мэдээллийн цаг” - ийн тоо, хамрагдсан албан хаагчдын хувь | 2023 оны Мэдээллийн цагт хамрагдсан албан хаагчдын хувь | Яамны “Мэдээллийн цаг”-ийн төлөвлөгөөг хагас жил тутамд батлуулж, зохион байгуулалтыг хангасан байна. | Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хаагчдын Мэдээллийн цагийн 2024 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг албан хаагчдаас санал авч, хариуцах газар, хэлтэс, мэргэжилтэн бүрээр батлуулав. Эхний хагас жилд 8 газар санал өгсөн. ДББУЗГ-аас "Оюутан цэрэг" хөтөлбөрийн танилцуулга, ТЗУГ-аас Нура төвийн их эмч С.Цэрэнпагма "Витаминны хэрэглээ болон багц оношилгооны талаар, ХӨДӨЛМӨРИЙН | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ-ийн ХАБЭА-н сургалт хариуцсан мэргэжилтэн Х.Дарьсүрэн "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал"-р, ЕББУЗГ-аас 21 дүгээр зууны боловсрол-Насан туршийн суралцахуй" сэдвээр, ШУТБИХХЗГ-аас Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент".сэдвээр Философийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М. Анара (Ph.D) хийлээ. Мөн Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Отгонцэцэг цаг үеийн асуудлаар холбогдох мэдээллилбан хаагчдад хүргэв. Үүнд албан хаагчдаас эрүүл мэндийн үзлэг оношилгооны талаар авсан судалгааны дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, сэтгэл ханамжийн судалгааны дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тус тус танилцуулав.<br>Боловсролын яамны албан хаагчдын Мэдээллийн цагийг 2024 оны сүүлийн хагас жилд дараах сэдвүүдийн хүрээнд зохион байгуулав. "Үндэсний | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгийн анхан, дунд, ахисан түвшний сургалт"-ын талаар Төрийн захиргааны удирдлагын газрын ажилтан О.Төгөлдөр, "Хөгжил ба мэдлэ"г сэдвээр Датаком компанийн үүсгэн байгуулагч Д.Энхбат, "Боловсролын салбарын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл" сэдвээр Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын яамны албан хэрэг хөтлөлтийн журмын тухай баримт бичгийн боловсруулалтын явцын талаар Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Алтансүх, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын яамны албан хаагчдын дунд зохион байгуулах спортын арга хэмжээний талаарх мэдээллийг Спортын зөвлөлийн дарга бөгөөд Цахим боловсролын газрын дарга Т.Бат-Эрдэнэ нар тус тус хийв. Албан хаагчдын оролцоо 90 хувь байв. Хавсралт: 4 файл | | |
| 6 | Эйбл системийн | Эйбл систем дэх | 2023 онд | Яамны дотоод | Хурал, уулзалтын | 1-р сар, | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дотоод үйл ажиллагааг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлнэ. | ашиглаж буй программын тоо | ашиглаж байсан программын тоо | зохион байгуулалтын үйл ажиллагаанд эйбл системийг бүрэн ашиглаж эхэлсэн байна. | өрөөнүүдийн захиалгыг Эйбл системийн Захиага зэсэд оруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэв. Ингэснээр албан хаагчид хаaанаас ч хурлын өрөөнүүдийн захиалгыг хийх боломжтойгоос гадна аль өрөөнд ямар уулзалт, хурал болж байгаа талаар мэдээлэл авах боломж бүрдсэн. Мөн Цаг бүртгэл систем дэх чөлөө болон бусад ажлаар гадуур гарахад нэгжийн удирдлагад хүсэлт илгээх зэсийг ажилуулах, баталгаажуулахад дэмжлэг үзүүлэн ажилласан. Боловсролын яамны хурал болон уулзалтын өрөөний захилгаас харахад 7 хоногт дунджаар 15-17 уулзалт, хурал болж байна. Эйбл системд албан хаагчдад чиглэсэн Хөдөлмөрийн дотоод журам, утасны жагсаалт, албан хэрэг хөтлөлтийн журам зэрэг шаардлагатай мэдээллийг тогтмол шинэчлэн оруулав. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 7 | Яамны хүндэтгэлийн танхим болон хурал, уулзалтын өрөөний цагийн хуваарь гаргах зохион | Уулзалт, хурлын өрөөний цагийн хуваарь | 2023 оны уулзалт, хурлын өрөөний хуваарь | Уулзалт, хурлын өрөөний цагийн хуваарь | Боловсролын яамны хүндэтгэлийн танхим, хурал, уулзалтын өрөөний захиалгыг эйбл системийн захиалга цэсэд оруулах ажлыг зохион байгуулав. Ингэснээр албан хаагчдад | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулалтыг хийнэ. | | | | өрөөний захиалга нээлттэй болсноор хурал, уулзалтын цаг давхардахгүй байх, хаана, ямар уулзалт, хурал болж байгаа талаар мэдээлэл авах боломж бүрдлээ. | 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 8 | Яамны албан хаагчдын цаг бүртгэлд хяналт тавьж, мэдээг нэгжийн даргад улирал тутамд гаргаж өгнө. | Цаг бүртгэлийн мэдээ | Албан хаагчдын 2023 оны цаг бүртгэлийн мэдээ | Албан хаагчдын цаг бүртгэлийн мэдээг улирал тутам гаргаж, нэгжийн даргад хүргүүлнэ. | Албан хаагчдын цагийн бүртгэлийн мэдээллийг сард 2 удаа газар, хэлтсийн ахлах шинжээч нараар гаргуулан, нэгжийн даргаар нь зуруулан баталгаажуулан яамны нягтлан бодогчид хүргүүлж ажиллаа. Албан хаагчдын цагийн бүртгэлийн системд гадаад, дотоод томилолт, ээлжийн амралтын мэдэгдлийн дагуу тухай бүр оруулан, хяналт тавьж ажиллав. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар гадаад, дотоод томилолтоор болон сургалттай болон өвчтэй, чөлөөтэй байсан албан хаагчдын мэдээллийг Цаг бүртгэлийн системд оруулав. | 4-р сар, 8-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 9 | Боловсрол, шинжлэх ухааны яамны ахмадын хороо болон Монголын ахмад | Тушаал, шийдвэр, зохион байгуулагдсан арга хэмжээ | 2023 онд гаргасан шийдвэрийн тоо, зохион байгуулсан арга | Холбогдох үйл ажиллгааны зардлын тушаал батлуулж, хэрэгжилтийг | Боловсрол, шинжлэх ухааны яамны Ахмадын хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллахад шаардагдах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | багш нарын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | | хэмжээ | хангахад дэмжлэг үзүүлнэ. | төсвийг 2024 оны А/08 дугаар тушаалаар батлав. Яамны удирдлагаас Боловсрол, шинжлэх ухааны яаманд ажиллаж байсан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, "Боловсррол, шинжлэх ухааны түүхэн хөгжил" ном бүтээх, хэвлүүлэх, "Боловсрол, шинжлэх ухааны бодлого, уламжлал, шинэчлэл" эрдэм шинжилгээни хурал зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлж байна. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Зардал батлах тухай" А/46 дугаар тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны яам, Монголын ахмад багш нарын холбоо хамтран 2024 оны үйл ажиллагааны гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг батлав. Монголын ахмад багш нарын холбоо нь 2024 онд Боловсролын багц хууль сурталчлах хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, Тэргүүний холбоо, бүтээлч багш, тэргүүний удирдах ажилтныг шалгаруулж , туршлага солилцох залуу багш нарт | 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөн туслах, “Багш эрдэнэ” сэтгүүлийн 2 дугаарын эхийг бэлтгэн, хэвлүүлэх тус тус ажлыг хэрэгжүүлээд байна. Яамны ахмадын хороог 2024 оны 09 дүгээр сард Засгийн газрын 3 дугаар байр, яамны 1 дүгээр давхарт байршуулж, тэдний ажиллах тухтай нөхцлийг бүрдүүлэв. Хавсралт: 2 файл | | |
| 10 | Салбарын шагналын тэмдэг, үнэмлэх, жуух хэвлүүлэх төсвийн төслийг боловсруулж батлуулах, хэвлүүлэх ажлыг зохион байгуулна. | Боловсрол, шинжлэх ухааны салбарын тэмдэг, үнэмлэх, жуух | 2023 ондз хэвлүүлсэн тоо | Боловсрол, шинжлэх ухааны салбарын тэргүүний үнэмлэх болон жуух хэвлүүлэх төсвийн төслийг боловсруулж, танилцуулсан байна. 2. Салбарын тэргүүний үнэмлэх, жуухыг хэвлүүлэх ажлыг зохион байгуулна. | Боловсрол, шинжлэх ухааны яамын Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн "Зардал батлах тухай" А/34 дүгээр тушаал, 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн Зардал батлах А/109 дүгээр тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны салбарын тэргүүний ажилтны хүндэт тэмдэг, үнэмлэх, хавтас үйлдвэрлэн нийлүүэхэд шаардагдах зардлыг батлав. Боловсрол, шинжлэх ухааны яамын Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн "Зардал батлах тухай" А/34 дүгээр тушаалаар батлагдсан төсвийн | 3-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүрээнд Салбарын тэргүүний ажилтны тэмдэг, үнэмлэх, хавтас хэвлүүлэн хүлээн авлаа. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/62 дугаар тушаалаар А/109 дүгээр тушаалаар баталсан зардаар салбарын хүндэт тэмдэг, жуух, хавтас үйлдвэрлэн нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулав. Үнэлгээний хороо хуулийн хугацаанд санал ирүүлнэ.<br>Хавсралт: 3 файл | | |
| 11 | Монгол Улсын цол, төрийн одон медальд нэр дэвшигчдэд төрийн захиргааны байгууллагаас санал өгөх ажлыг зохион байгуулна. | Салбарын байгууллага, болон яамны албан хаагчдыг шагналд тодорхойлон ЗГХЭГ-т, аймаг, нийслэлийн Засаг даргад /Төрийн дээд шагналд дэмжиж/ хүргүүлсэн албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн тоо | 2023 онд Төрийн дээд шагналд дэмжиж/ хүргүүлсэн албан бичгийн тоо, шийдвэрлэлтийн тоо | ЗГХЭГ-аар уламжилсан тодорхойлолтын мөрөөр ажиллаж, Ерөнхийлөгчийн зарлигаар олгосон шагналыг гардуулах ёслолын ажиллагааг зохион байгуулж, ЕТГ-т тайлангаа хүргүүлсэн байна. Аймаг, нийслэлийн Засаг даргын ирүүлсэн Төрийн дээд шагналд нэр дэвшигчдийн баримт бичгийг судалж, тухай бүр дэмжих эсэх | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оын 71 дүгээр Зарлигаар баталсан "Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам"-ын дагуу Боловсрол, шинжлэх ухааны салбарын албан хаагчдыг Төрийн одон медалиар шагнуулахаар холбогдох байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг судлан ЗГХЭГ, ЕТГ-т албан тоот хүргүүлэв. 2024 онд журмын дагуу Боловсрол, шинжлэх ухааны салбараас 455 багш, ажилтныг шагнуулахаар материалыг дээд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | талаар албан бичгээр хариу өгсөн байна. | байгууллагт уламжилсан байна. Салбарын сайд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн одон медаль хүртсэн 198 багш, ажилтан, албан хаагчдад гардуулав. | | |
| 12 | Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хүсэлт гаргасан Улсын цол, төрийн одон медальд нэр дэвшигчдийн мэдээллийн санг бий болгоно. | Мэдээллийн сан | 2023 оны бүртгэлийн тоо | Төрийн одон медальд санал өгсөн иргэдийн сангийн баяжилт хийж, 2024 оны хагас жилийн нийт тоог гаргана. | Боловсролын яамнаас хүсэлт гаргасан Улсын цол, төрийн одон медальд нэр дэвшигч болон шагнагдсан иргэдийн мэдээллийн санг бий болгоод байна. Сангийн мэдээлэлд 2024 онд нийт 450 орчимд багш, ажилчдын мэдээлэл орсон байна. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 13 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай | Батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө | ТАХ-ийн 2023 онд баталсан төлөвлөгөө | ТАХ-ийн гүйцэтгэлийн сүүлийн хагас жилийн биелэлтийг тайлагнасан, мэдээллийг цаг тухайд бэлтгэсэн байна. | Төрийн албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хугацаанд нь батлуулав. 2024 эхний хагас жилийн болон жилийн эцсийн тайланг хугацаанд нь хүргүүлэв. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | | | | гүйцэтгэсэн байдал: 100% |
| 14 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо | 2023 онд шийдвэрлэсэн албан бичиг | Албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг журамд заасан хугацаанд хариу өгөх | 2024 онд эхний хагас жилд нийт 76 иргэнээс өргөдөл ирсэн байна. Ирсэн өргөдлүүдийн дийлэнх нь салбарын тэргүүний тэмдгээ гээсэн, нөхөж авах хүсэлтэй байгаагаа дурдсан байдаг. Салбарын тэмдэг нөхөн олгох журмын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэлтийг хангуулан, шийдвэрлэн ажиллав. Нийт 44 иргэнд Салбарын тэмдэг нөхөн олгосон байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийг холбогдох албан тушаалтан, албан хаагчдаас санал, чиглэл авч хариуг хүргүүлж ажиллаа. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Салбарын болон Төрийн албаны хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг судалж мөрдөж ажиллах | Холбогдох хууль, тогтоомжийг судална. | 2023 он | Салбарын болон Төрийн албаны хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг судалж мөрдөж ажиллах | Ажлын байрны чиг үүргийн дагуу болон салбарын, Төрийн албаны хууль тогтоомжийг судлаан, мөрдөн ажилласан. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70% |
| 2 | Байгууллагын мэдээллийн цаг, бусад холбогдох сургалтад хамрагдана. | Цаг үеийн холбогдох сургалтад хамрагдана. | 2023 онд сургалтад хамрагдсан тоо | Мэргэжил дээшлүүлэх сургалт, мэдээллийн цагт хамрагдана. | 1.Боловсролын яамны албан хаагчдын Мэдээллийн цагийн төлөвлөгөө батлуулан, зохион байгуулалтыг хийж, хамрагдсан. 2.Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн захирлын 2024 оны А/93 тоот тушаалаар Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдан R2081 сертификат авсан. 3.Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас 2024 оны 11 дүгээр сарын 04,05-ны өдрүүдэд | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан "Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь" сургалтад хамрагдан 24/1993 үнэмлэх авсан. 4.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг "7:4:10" цахим сургалтад хамрагдсан. Хавсралт: 2 файл | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Яамны дотоод асуудал, шагнал хариуцсан ахлах мэргэжилтэн, Мягмар Уранзул /................................................/ Огноо: .........................